

ЯЛЫН ГЭМТ ХЭРГИЙГ ТОГТООН БАРИХ СОНГОДОГ КРИМИНОЛОГИЙН НОМЛОЛЫН ҮНДЭС¹ /XVIII ЗУУН/

CLASSICAL CRIMINOLOGY AND THE DETERRENCE DOCTRINE¹

¹ Роналд Л. Эйкэрс, Кристин С. Селлерс нарын "Criminological Theories: Introduction, Evaluation, and Application" **сүрах бичгээс "Classical Criminology and Deterrence Doctrine" хэсгийг хэсэгчлэн авч орчуулав.**

¹ This article is a work of translation as the information contained within this paper encompasses sections from "Classical Criminology and Deterrence Doctrine" from "Criminological Theories: Introduction, Evaluation, and Application" by Ronald L. Akers and Christine S. Sellers.



Г.ЛХАГВАМАА

Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академийн Аюулгүй байдлын удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор, дэд хурандаа

LKHAGVAMAA G.

(Ph.D. & Lt.Colonel) Associate Professor of the Professor's Team for Security Management and Strategy of the Academy of Management, Law Enforcement University

Товч агуулга: Криминологийн сонгодог онолын төлөөлөгчид бол Италийн эрдэмтэн Цезари Беккарий, Английн эрдэмтэн Жереми Бентам нар юм. Тэдний боловсруулсан онолын гол үзэл баримтлал хууль оноох ялын хатуу чанга байдлыг хангахад дан ганц оршдоггүй, харин эрүүгийн ялын гэмт хэргийг тогтоон барих үүднээс авч үзвэл ял гарцаагүй байх болон ялыг хурдан шуурхай оногдуулах мөн чанарт оршдог гэж үздэг.

Abstract: The founding fathers of classical criminology are the Italian criminologist Cesare Beccaria and the English philosopher Jeremy Bentham. The main concepts of their theory lie in not the severity of punishment but the certainty and celerity of criminal sanctions which effectively deter people from committing crime.

Түлхүүр үгс: Гэмт хэргийг тогтоон барих, ял хатуу, чанга байх, ял гарцаагүй байх, ялыг хурдан шуурхай оногдуулах.

Keywords: Deterrence, severity, certainty, celerity of punishment.

Сонгодог криминологи XVIII дугаар зуунд Италийн эрдэмтэн Цезари Беккарий, Английн эрдэмтэн Жереми Бентам нарын бүтээлүүдэд анх хөндөгдсөн байдаг. Энэхүү хоёр эрдэмтэн гэмт зан үйлийг томьёолон тайлбарлахаас илүүтэйгээр эн тэргүүнд эрх зүйн болон ялын шинэтгэлийн асуудалд анхаарал хандуулсан прагматик бөгөөд нийгмийн чиглэлийн үзэл баримтлалтай гүн ухаантнууд байсан. Ийм ч учраас тэдний томьёолсон гэмт хэргийн тухай онол өнөөгийн криминологийн шинжлэх ухаанд ач холбогдлоо алдаагүй байна.

Сонгодог криминологчдын өөрчлөхийг зорьж байсан эрх зүй, шүүх болон ялын тэрхүү тогтолцоог тухайн цаг үед Европын ихэнх орнуудын шүүхээс дураар авирлах, алагчлан ялгаварлаж субъектив хандлагаар шийдвэр гарган бусниулж байв. Тухайн үед эрүү шүүлт тулган хүчээр ял хүлээлгэх, ташуурдах, олон нийтийн өмнө дүүжлэх, эрэмдэг зэрэмдэг болгох зэргээр бие махбодыг тарчлаан хэрцгий шийтгэх нь ердийн үзэгдэл байлаа. Сонгодог криминологчид эрх зүй болон шүүхийн тогтолцоог илүү оновчтой, шударга болгохын тулд шинэтгэл хийх, ингэхдээ уг асуудалд гүн ухааны үзэл номлол, шинжлэх ухаанчаар хандах зорилготой байсан. Тэдний үзэл санаа нь тухайн үеийн нийгэмд өсөн нэмэгдэж байсан дунд давхаргын худалдаачдын ашиг сонирхолтой нийцэж, худалдаа, арилжаа, аж үйлдвэржилтийг хөхүүлэн дэмжих талаарх эдийн засгийн бодлого, үзэл баримтлалтай ч тохирч байлаа. Тэд тухайн үеийн тэргүүний сэхээтнүүдийн олонхын дэмжлэгийг авч байсан ба эрх зүйн шинэтгэлийг хөхүүлэн дэмжихийг зорьж байв. Тэдний дэвшүүлсэн үндэслэлүүд төрийн удирдлагад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрд ардчилсан хяналт тогтооход чиглэсэн улс төрийн хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаатай яв цав нийцэж байлаа.

Ер бусын харгис хэрцгий болон хуумгай ялыг үл хэрэглэх талаар сонгодог прагматик философичдын зүгээс дэвшүүлж байсан энэхүү онол түүний хүрээнд хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн нэлээд хэсэг нь АНУ-ын Үндсэн хууль, Хүний эрхийн тунхгийн нэмэлт өөрчлөлтөд тусгалаа олсон байв. Түүнчлэн,



Хууль сахиулахын
их сургуулийн
Хууль сахиулахын
удирдлагын
академийн
Аюулгүй байдлын
удирдлага,
стратегийн
профессорын
багийн дэд
профессор,
хууль зүйн
ухааны доктор,
дэд хурандаа

Францын хувьсгалын дараагаар Францын 1791 оны шинэ хуулиудад ч гэмт хэргийн төрөл, гэмт хэргийн ангилал тус бүрд тохирсон ялыг оногдуулах талаар холбогдох бусад заалтуудад ч тусгалаа олжээ.

ЯЛ ГАРЦААГҮЙ БАЙХ, ХАТУУ ЧАНГА БАЙХ БОЛОН ЯЛЫГ ХУРДАН ШУУРХАЙ ОНОГДУУЛАХ МӨН ЧАНАР

Ялын хатуу, чанга байх, гэмт хэрэгт тохирсон байх үндэслэл.

Хүмүүс өөрсдийн хүсэл зоригуу зүй зохистойгоор илэрхийлэхийн тулд аливаа үйлдэл хийж, шийдвэр гаргадаг гэсэн үндэслэл нь сонгодог криминологийн онолын гол суурь тулгуур мөн. Хувь хүн бүр аливаа нэг үйлдлээс урган гарах эрсдэлийг, бүр эсрэгээр түүнээс авах таашаал, ашиг орлого зэргийг харгалзан хуулийг дагаж мөрдөх, аль эсвэл түүнийг огоорон зөрчих эсэх сонголтоо хийдэг. Мөн гэмт зан үйлийг сэдэхдээ хуулиар оногдуулж болзошгүй ял, баригдах болон ял шийтгэгдэх магадлалыг харгалзан үздэг. Хэрвээ тэд гэмт хэрэг үйлдэн олж болох ашиг орлогоос эдлэх ял, амсах цээрлэл нь илүү их байх аюул байна гэж үзвэл гэмт хэрэг үл үйлдэнэ. Тэд өөрсдийн урьд өмнө ял эдэлж байсан туршлага, аль эсвэл хуулиар гэмт хэрэгт ямар ял оногдуулдаг талаарх мэдлэг, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж байсан хүмүүст ямар ял оногдуулж байсан талаарх ойлголт зэрэгт тулгуурлан гэмт үйлдлээ нарийвчлан төлөвлөж тооцоолдог.

Хэрэв эрх зүйн тогтолцоо өөрөө тогтворгүй, тодорхой бус байвал зүй зохистой ямар нэгэн шийдвэр гаргах хангалттай баталгаа болж чадахгүй.

Ийм тогтолцоо нь шударга бус бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй хэрэглүүр болж чадахгүй. Иймд, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд эрүүгийн эрх зүй нь ард иргэдийн зүгээс хууль зөрчихгүй байхаас илүү хуулийг чанд сахин мөрддөг байх явдлыг хангах үүднээс хэрэглэж болохуйц, оновчтой төрөл, хэлбэрийн тохирсон ялыг тогтоож өгөх ёстой. Гэмт хэргийг тогтоон барих нь эрүүгийн эрх зүйн эн тэргүүний зорилго мөн. Гагцхүү төр буюу хохирогчид учруулсан хохирлыг барагдуулах үүднээс гэмт хэргийг тогтоон барих арга хэрэгслийг ашиглах ёсгүй. Хууль тогтоогчид чухамхүү ямар үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх, гэмт хэргээс учруулсан хохиролтой дүйцэхүйц ялыг хуульчлах, үүнтэй уялдуулан гэмт хэргээс ашиг олох явдлыг таслан зогсоохуйц

байдлаар хууль зөрчсөн этгээдэд оногдуулах ялыг тодорхойлсон тийм хуулиудыг батлан гаргаж, тэгснээр иргэдийн зүгээс гэмт хэрэг үйлдэх явдлыг тогтоон барьж чадна.

Шүүгчид зөвхөн гэмт хэрэгтний гэм буруутай болон гэм буруугүй эсэхийг тогтоох ёстой бөгөөд хуульд заасан ялыг өөрчлөлгүйгээр хэрэглэх учиртай. Ял нь үйлдсэн гэмт хэрэгтэй яв цав тохирсон байх ёстой. Энэ нь “Нүдийг нүдээр, шүдийг шүдээр” гэсэн залхаан цээрлүүлэлт шиг тайлбарлагдаж болох юм. Гэхдээ, ялыг гэмт хэрэгтэй дүйцүүлэн хэрэглэх тал дээр Ц.Беккарий, Ж.Бентам нар ял нь нийгэмд учруулсан хор аюулаас илүү байх ёстой гэж үзэж байв. Энэ нь, гэмт хэргээс учирсан хор аюулыг арилгахын тулд ялыг хатуу чанга байхуйцаар нарийвчлан хуульчилж тогтооно гэсэн үг юм.

Тодорхой гэмт хэрэг үйлдсэнээс олох олз ашиг буюу авах таашаалын хэмжээ хувь хүн бүрийн тухайд бараг ижил тэнцүү байдаг гэсэн ойлголт төсөөлөл энэхүү үндэслэлийн цаана оршиж байгаа. Тийм ч учраас, ялыг гэмт хэрэгтэй ягштал уялдуулаад өгчихвөл, эсрэг утгаараа ял шийтгэл нь хувь хүнд тохирсон байхаар болчихно. Хуулиар ялыг шууд тодорхой төрлийн гэмт хэрэгт оноож хэрэглэх ёстой, төдийгүй гэмт хэргийн нөхцөл байдал, гэмт хэрэгтний хувийн зан чанарт тохирсон янз янзын ял байх ёстой. Энэ үндэслэлийн дагууд авч үзвэл, гэмт хэрэг хэдий чинээ их ноцтой буюу хор аюултай байх тэр хэмжээгээр гэмт хэрэгтэн хувь хүн түүнээс завших олз ашиг бас төдий чинээ их байна гэсэн үг. Тийм учраас гэмт хэрэг ноцтой байх тэр хэмжээгээр оногдуулах ял ч бас улам хүнд байвал л тухай тухайн гэмт хэргийг тогтоон барих боломжтой.

Хууль тогтоогчид тухайн гэмт хэрэгтний хувийн онцлог байдлыг харгалзахгүйгээр, гагцхүү үйлдэгдсэн гэмт хэрэг тус бүрд тохируулан оногдуулах ялыг оновчтой хуульчлах үүднээс үйлдсэн гэмт хэрэг болон түүнд оноох ялыг эн тэнцүүлж дүйцүүлэх, тэрхүү үзэл баримтлалыг криминологийн сонгодог онолд томьёолон авч үздэг байв. Харин хүний нас болон сэтгэцийн чадвар нь тухайн хүний хариуцлага хүлээх чадамжид нөлөөлж болох талтай хэмээн үзээд энэ үзэл баримтлалыг хожим хойно нь өөрчилсөн байна.

Ялын гарцаагүй байх ба ялыг хурдан шуурхай оногдуулах:

Гэмт хэргийг тогтоон барих номлол хуулиар оноох ялын хатуу чанга байдлыг хангахад дан ганц оршдоггүй. Тиймээс ч,



эрүүгийн ял нь гэмт хэргийг тогтоон барих үүднээс авч үзвэл гарцаагүй бөгөөд шуурхай байх ёстой хэмээн тодорхойлдог. Шуурхай байх гэдэг нь гэмт хэргийн үйлдлийн мөрөөр тухайн гэмт хэрэгт эрүүгийн ямар ялыг тохирохыг хойшлуулахгүйгээр хурдан шуурхай оноход оршино.

Гэмт хэрэг үйлдэгдсэний дараа ялыг хэдий чинээ нэн даруй оногдуулна, тухайн ял төдий чинээ шударга, үр өгөөжтэй болдог...Ялыг нэн даруй оногдуулбал илүү үр өгөөжтэй. *Яагаад гэвэл гэмт хэрэг болон түүнд оноох ялын хоорондын хугацаа богино байх тусам, гэмт хэрэг болон ял гэсэн энэ хоёр ухагдахууны өөр хоорондын уялдаа авцалдаа баттай бөгөөд хөдөлшгүй болж өгдөг /Беккариа 1972. 18-19/.*

Гарцаагүй байх гэдэг нь аливаа гэмт хэргийн магадлалыг танин нягталж, ялыг зайлшгүй тодорхойлоход оршино. Гэмт хэрэгт оногдуулах ял нь хатуу чанга, гарцаагүй, шуурхай байж чадвал, энгийн олон түмэн ч бас гэмт хэрэг үйлдвэл ашиг орлого олохоосоо илүү ихээр алдаж, хохирох юм хэмээн зүй ёсоор үзэж тооцоолон, хууль зөрчихөөс болгоомжлон цэрвэх байдалд хүрэх болно. Ц.Беккарий, Ж.Бентам нарын аль нь ч ялын гарцаагүй байх болон хатуу чанга байхын хоорондын холбоог олж харсан. Ял гарцаагүй байх явдал нь ял хатуу

чанга байхаас ч илүү үр нөлөөтэйгөөр гэмт хэргийг тогтоон барих талтай. Ял илүү хатуу чанга байхын хирээр тухайн ялыг арай бага хэрэглэх магадлал ихтэй байх бөгөөд харин ялын гарцаагүй байдал сулрах тутам гэмт хэргийг тогтоон барихад илүү их хүндрэл учирдаг гэж тэд үзэж байв.

Гэмт хэргийг тогтоон барих ерөнхий болон тусгай арга.

Уг онолын хүрээнд гэмт хэргийг тогтоон барих боломжийг хангаж болохуйц 2 арга хэлбэр байдаг. Эхнийх нь арга хэлбэрийн хувьд гэвэл, хэрэв ял шийтгүүлсэн этгээд нь гарцаагүй, хатуу чангаар шийтгүүлсэн бол дахин гэмт хэрэг үйлдэхээс татгалзах явдал болно. Гэмт хэргийг тогтоон барих энэхүү арга хэлбэрийг "тусгай" буюу "онцгой арга хэлбэр" гэдэг. Хоёрдох арга замын тухайд гэвэл, энэ нь "гэмт хэргийг тогтоон барих ерөнхий арга" буюу гэмт хэрэгтэнд төрийн нэрийн өмнөөс оногдуулах эрүүгийн хариуцлага /ял/ мөн тул /гэмт хэрэг хараахан үйлдээгүй/ бусад хүмүүст санамж сануулга болон үйлчилж, тэднийг гэмт хэрэг үйлдэхгүй, тогтоон барих үүднээс төрийн шийтгэлээс эмээн цэрвэх үзэл бодлыг тэд нарт суулган хоногшуулахад оршино.